



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2017 оны 04 сарын 27-адар

АКТ
Дугаар 65

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Баянхонгор сумын 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтанд нийцлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон тэмсний үрийн сангаас 1 кг тэмсний үрийг 700 төгрөгөөр тооцож, иргэдэд 6500 кг буюу 4225,9 мянган төгрөгийн тэмсний үрийг гэрээ байгуулж зээлээр олгосноос 2753,6 мянган төгрөгийг төлүүлээгүй.

2. Тус сангаас сумын ЗДТГ-ын ажиллагсадад 500 кг буюу 350,0 мянган төгрөгийн тэмсний үр олгосон гэх боловч хэнд өгсөн нь тодорхойгүй, түүнийг нотлох баримт байхгүй бөгөөд тэмсний үнийг төлөөгүй зөрчил илэрлээ.

Энэ нь 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн сумын ЗДТГ-ын Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтний иргэдтэй байгуулсан гэрээний 1.3-т заасан "Зээлдэгч нь зээлээр авсан үрийн тэмсийг 2016 оны намрын ургацаас 2016 оны 10 дугаар сарын 20-ны дотор хүснэгт 1-ийн 5 дахь баганад заасан мөнгийг төлнө" гэснийг зөрчсөн байна.




Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөгдөөгүй тэмсний үрийн 2753,6 мянган төгрөгийг гэрээ байгуулж үрийн тэмсний үнийг төлөөгүй иргэдээр, 350,0 мянган төгрөгийг тэмсний үр авсан сумын ЗДТГ-ын ажилчдаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2517003

2. Аудитаар тогтоосон 3103,6 мянган төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад төлбөр хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.
3. Аудитаар тогтоосон 3,103,600 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2017.06.30-ний дотор Баянхонгор аймгийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор сумын Засаг дарга Ж.Мөнхсоёл, мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргжилтэн С.Эрдэнэ нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН¹:  АУДИТОР:  Б ДОЛЖМАА	 ЗАСАГ ДАРГА:  Ж.МӨНХСОЁЛ МЭРГЭЖИЛТЭН:  Э.МӨНХТУЯА МЭРГЭЖИЛТЭН:  С.ЭРДЭНЭ
--	--

1. Акт, албан шавьрдлагын бивэлжит ханцаадзахауй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дүвээр зүйлийн 28.2-д зассан "Төрийн аудитын байдууллахаас төвсэн албан шавьрдлаад, талборийн лятыг цаг хувцасанд нь биелиүүлэхэй тохиолдолд зорчил гараласан албан тушаалтныг уурзжээжилжээ нь хэлхэг тухай саналын төрийн аудитын байдууллахаас эрх бүхий албан тушаалтанд хураулна" ээж засгийн давуу хариуцаач албан тушаалтанд харшуулсаа ноодууллахаар эрх бүхий албан тушаалтанд санал хурауулна.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТОРИЙН АУДИТИН ГАЗАР

2017 оны 04 сарын 27-дээр

АКТ
Дугаар 66

Номон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитийн газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Баянбулаг сумын 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтанд нийцлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ОНХС-ийн хөрөнгөөр Сайрын амны худаг сэргээн засварлах 7,9 сая төгрөгийн ажлыг "Чорьж бүрд" ХХК зураг төсөвгүй гүйцэтгэсэн ба авсан санхүүжилтийг худгийн барилгын ажлын гүйцэтгэлтэй тулган шалгахад 1,8 сая төгрөгийн материалыг дутуу зарцуулсан байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх "Барилгын ажил гүйцэтгэгч ...барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсвэл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоо, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Гэрээнд заасан үүргээ дутуу биелүүлсэн "Чорьж бүрд" ХХК-аар 1,8 сая төгрөгийг Баянбулаг сумын ОНХС-ийн дансанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов
2. Аудитаар тогтоосон 1,800,000 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2017.06.30-ний дотор Төрийн аудитын газарт

2517006

ирүүлэхийг Баянбулаг сумын Засаг дарга Р.Жамъяндорж, санхүүгийн албаны
дарга Л.Дулмаа нарт хариуцуулав.



* Аж, албан шаардлагын билэлтийг хянавадааэй тогтолцоой Төрийн аудитын тухай хуулийн 28 дүвээр зүйлийн 28.2 б эзслэн "Төрийн аудитын байдгууллаагаас төмсэн албан шаардлага, төлбөрийн ажлын цэс хувьцаанд нь биелийн тогтолцоой зөрчилт гаргасан албан тушаалтынч уурзат шийлас нь холах тухай саналын төрийн аудитын байдгууллаагаар эрх бүхий албан тушаалтын хуразуулна" ээж эзслэны дээнуу харцуулаач албан тушаалтанд хариуцлаа нийдүүлэхээд эрх бүхий албан тушаалтын санал хурауулна.



2017 оны 04 сарын 27-өдөр

АКТ
Дугаар 67

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Жаргалант сумын 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтанд нийцлийн аудит хийхд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгөөс "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨК Баянхонгор аймгийн газарт "Үл хөдлөх хөрөнгийн цахим бүртгэл" төсөл арга хэмжээний шугамын ажлын интернетийн урсгал зардалд 6,5 сая төгрөгийг урьдчилж телсэн атлаа авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ..." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлберийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Интернетийн төлбөрт урьдчилж телсэн 6,5 сая төгрөгийг "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨК-ний Баянхонгор аймгийн газраар төлүүлж, төлберийг Жаргалант сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлэхээр төлберийн акт тогтоов.

2. Аудитаар тогтоосон 6,500,000 төгрөгийн төлберийн актыг барагдуулсан тухай баримтыг 2017.06.30-ний дотор Баянхонгор аймгийн

2517007

аудитын газарт ирүүлэхийг Жаргалант сумын Засаг дарга Д.Сайнбилэг,
санхүүгийн албаны дарга Д.Азжаргал нарт хариуцуулав.



¹. Акт албан шаарблэвэйн бивэлжилт хангаждажаагүй тогхицдолд Төрийн аудитын тухай хурулийн 28 дувавр зүйлийн 28.2-д зассан "Төрийн аудитын бедэууллахаас төвьсан албан шаардлага, төлбөрийн амьтны цаг хувацаанд нь бивэлжүүлэхэд тогхицдолд зорчил гаралсан албан тушаалтныг үүрэгт вийнэс нь хялех тухай саналыг төрийн аудитын бедэууллахаас эрх бүхий албан тушаалттай хургуулна" эж засны бээсуу харгууцавч албан тушаалтанд харшуулсаны тохиулалтад эрх бүхий албан тушаалттай санал хургуулна.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

2017 оны 04 сарын 27-аадар

АКТ
дугаар 68

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Бөмбөгөр сумын 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтанд нийцлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ОНХС-ийн хөрөнгөөр сумын ЗДТГ-т 1,3 сая төгрөгийн үнэ бүхий компьютер худалдан авсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4 дүгээр зүйлийн 4.4-т заасан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлсэн урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. ЗДТГ-ын хэрэгцээнд худалдан авсан компьютерийн үнийн 1,3 сая төгрөгийг ЗДТГ-ын төсвөөс төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад төлбөр хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.
2. Аудитаар тогтоосон 1,300,000 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2017.06.30-ний дотор Баянхонгор аймгийн аудитын газарт


2517009

ирүүлэхийг Бөмбөгөр сумын Засаг дарга Н.Мөнжаргал, санхүүгийн албаны
дарга Б.Нарангэрэл нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН:

АУДИТОРЫН Б. ДОЛЖМАА



ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСАГ ДАРГА Н. МӨНЖАРГАЛ
САНХҮҮГИЙН
АЛБАНЫ ДАРГА Б. НАРАНГЭРЭЛ



¹. Акт, албан шаардлын бивэхийн хангаждажай тогтолцоолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дэвэр зүйлийн 28.2-д зассан "Төрийн аудитын байгуулалтад тавьсан албан шаардлага, төгрөгийн вийнэ цаг хувацаанд нь биелийн тогтолцоолд зөрчил гаралсан албан тушаалтныг үргэлжлэхэд нь хялбар тухай саналыг төрийн аудитын байгууллагеэс эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж" эсэх зөвсэн давнуу хариуцаж албан тушаалтанд хариуцалеэ нөхцүүлжээвэр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.